



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/175

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийх тухай” 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 07/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт Өвөрхангай аймгийн Сум дундын Ойн анги (РД:3553329) улсын төсөвт үйлдвэрийн газарт мод үржүүлгийн зориулалттай 2680609 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай 3,0 га газрыг 40 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэн, хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН